



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/31 ДУА-2018/97/СТА-ТЦЗ

Мандалговь хот

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд **270,000.00** /хоёр зуун далан мянган/ төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*/, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.4-т /*Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцног*/, Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын 1.1-д /*2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох*;/, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд: /*Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын дагуу 2017 онд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн игууд захирагч нарт баалгав* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсонгүй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /*Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал* гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урамшуулалд олгосон 270,000.00 /хоёр зуун далан мянган / төгрөгийг Л.Дэлгэрмаагаар нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Г.Оюунчимэг, нягтлан бодогч Н.Энхмарт нарт хариуцуулав.

ТОГТООСОН¹:
АУДИТОР: Т.ОЮУН-ЭРДЭНЭ



591 71 4713
300461 43 0033475

АКТЫГ

ЭРХЛЭГЧ: Г.ОЮУНЧИМЭГ
НЯГТЛАН БОДОГЧ: Н.ЭНХМАРТ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гэрэгасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.